



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/516

Мандалговь

Багш нарын урлагийн бага  
наадамд зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Монгол улсын Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4, аймгийн Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.4.9 дэх заалтууд, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн боловсролын байгууллагын багш ажилтнуудын урлагийн бага наадмыг 2017 оны 09 дүгээр сарын 21-ээс 23-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

Хоёр. Багш ажилтнуудын урлагийн бага наадмыг зохион байгуулах төлөвлөгөө гарган, бэлтгэлийг өндөр түвшинд хангаж, ардын авьяастан, биет бус өвлөн уламжлагчдыг илрүүлэн, тэднийг өргөнөөр хамруулж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /Ц.Бумангэрэл/, Төв Халхын дуулалт жүжгийн театр /Д.Доржсүрэн/, "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театр /А.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав. Зардлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Дөрөв. Урлагийн бага наадмын шагналын зардалд 2400000 /Хоёр сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200875